



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/338

Хэрлэн сум

Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт Хэнтий салбарт дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын Хэнтий аймаг дахь салбараас ирсэн хүсэлтийн дагуу Сүхбаатар аймагт болох Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын тасралтгүй хөгжлийн зүүн бүсийн сургалтын зардалд 10,000,000 (арван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ; зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ